БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн  “Өлгий сансар” эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/16/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер:  Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com<br>Аудитор: Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 9
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 11
4.1 Ерөнхий зүйл ........ 11
4.2 Материаллаг байдал ........ 12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
4.5.1 Завсрын аудитын талаар ........
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 13
5.1 Төлбөрийн акт ........ 13
5.2 Албан шаардлага ........ 13
5.3 Зөвлөмж ........ 13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН "ӨЛГИЙ САНСАР"
ЭМНЭЛЭГИЙН ЕРӨНХИЙ ЭМЧ
Д.САРА ТАНАА

2023.02.17 № 96

танай ____________-ны № ____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн "Өлгий сансар" эмнэлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн "Өлгий сансар" эмнэлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Өлгий сансар" эмнэлэгийн 2022 оны орлого өмнөх оноос 265.1 сая төгрөгөөр буурч өр төлбөр нэмэгдсэн нь үйл ажиллагааны тасралтгүй байдалд нөлөөлсөн байна.

**Аудитын гол асуудал**

Орлого бүрдүүлэлттэй холбоотой өр төлбөр барагдуулах асуудал хүндрэлтэй болсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,693,278.12** | **89,348,307.70** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 94,546.30 | 28,221.76 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 94,546.30 | 28,221.76 |
| 3121 | **Төгрөг** | 94,546.30 | 28,221.76 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 95,598,731.82 | 89,320,085.94 |
| 351 | **Түүхий эд материал** | 12,171,162.10 | 5,668,623.26 |
| 35130 | Эм боох материал | 12,171,162.10 | 5,668,623.26 |
| 354 | **Хангамжийн материал** | 83,427,569.72 | 83,651,462.68 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 865,114.00 | 4,075,114.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 77,588,566.90 | 72,809,354.90 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 163,000.00 | 163,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 869,730.00 | 796,529.96 |
| 35460 | Хүнсний материал | 3,851,875.20 | 5,718,180.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 89,283.62 | 89,283.62 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **442,295,618.43** | **402,003,073.10** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 442,295,618.43 | 402,003,073.10 |
| 392 | **Биет хөрөнгө** | 343,691,618.43 | 303,399,073.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 375,190,350.62 | 375,190,350.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (98,195,186.11) | (125,317,248.19) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 6,862,000.00 | 6,862,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (5,489,600.16) | (6,862,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 106,765,140.00 | 111,664,140.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (51,117,523.42) | (65,624,523.51) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,179,001.00 | 20,679,001.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,502,563.50) | (13,192,646.82) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 98,604,000.00 | 98,604,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 98,604,000.00 | 98,604,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **592,988,896.55** | **491,351,380.80** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **37,022,955.62** | **129,444,905.29** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 37,022,955.62 | 129,444,905.29 |
| 413 | **Өглөг** | 37,022,955.62 | 129,444,905.29 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 16,648,646.00 | 67,034,252.04 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 744,700.00 | 1,677,117.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 19,629,609.62 | 60,733,536.25 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 19,629,609.62 | 60,733,536.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **555,965,940.93** | **361,906,475.51** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 555,965,940.93 | 361,906,475.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 179,512,371.00 | 179,512,971.00 |
| 51101 | Өмч:  - төрийн | 179,512,371.00 | 179,512,371.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 68,707,315.57 | (125,352,149.85) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 68,707,315.57 | 68,707,315.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (194,059,465.42) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 307,746,254.36 | 307,746,254.36 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **592,988,896.55** | **491,351,380.80** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **873,375,042.00** | **498,215,090.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,136,702.00** | **7,579,665.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **867,238,340.00** | **490,635,425.00** |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 851,220,615.00 | 490,635,425.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 851,220,615.00 | 490,635,425.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **822,793,171.96** | **692,774,555.42** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **822,793,171.96** | **692,774,555.42** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 822,282,655.45 | 668,488,655.42 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 416,934,433.49 | 382,325,321.00 |
| 210101 | Үндсэн цалин | 416,934,433.49 | 382,325,321.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,140,938.78 | 48,392,475.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,140,938.78 | 48,392,475.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,478,239.00 | 23,239,617.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,102,539.00 | 6,953,217.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,820,500.00 | 14,737,200.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,555,200.00 | 1,549,200.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 21,368,702.03 | 29,821,662.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,776,300.00 | 1,872,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,432,950.00 | 5,034,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 932,471.00 | 880,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,000.00 | 2,709,750.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 15,066,981.03 | 19,325,912.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 183,777,187.66 | 120,089,731.57 |
| **210501** | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 146,936,693.66 | 102,298,486.57 |
| **210502** | Хоол, хүнс | 36,840,494.00 | 17,791,245.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,797,240.44 | 17,928,303.48 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,471,428.44 | 17,928,303.48 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,785,914.05 | 46,691,545.33 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,785,914.05 | 46,691,545.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 510,516.51 | 24,285,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 510,516.51 | 24,285,900.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 24,285,900.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **50,581,870.04** | **(194,559,465.42)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **50,581,870.04** | **(194,559,465.42)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **818,375,042.00** | **553,215,090.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,136,702.00** | **7,579,665.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| **1200041** | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,136,702.00 | 7,579,665.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **812,238,340.00** | **545,635,425.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 796,220,615.00 | 545,635,425.00 |
| **134002** | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 796,220,615.00 | 545,635,425.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **782,134,520.92** | **546,882,414.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **782,134,520.92** | **546,882,414.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **781,624,004.41** | **523,096,514.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 418,058,943.98 | 341,385,553.96 |
| **210101** | Үндсэн цалин | 418,058,943.98 | 341,385,553.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,772,830.39 | 37,994,200.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 55,772,830.39 | 37,994,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,642,939.00 | 18,775,600.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 7,102,539.00 | 6,870,000.00 |
| **210302** | Түлш, халаалт | 9,711,400.00 | 11,205,600.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 1,829,000.00 | 700,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,967,717.60 | 20,606,750.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 2,221,000.00 | 2,333,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 3,900,000.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 932,471.00 | 880,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 169,500.00 | 2,709,750.00 |
| **210407** | Аж ахуйн материал худалдан авах зардал | 17,644,746.60 | 10,784,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 190,374,833.00 | 85,518,671.10 |
| **210501** | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 154,618,250.00 | 59,540,671.10 |
| **210502** | Хоол, хүнс | 35,756,583.00 | 25,978,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,806,740.44 | 18,815,739.48 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,471,428.44 | 17,928,303.48 |
| **210807** | Газрын төлбөр | 295,812.00 | 887,436.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **510,516.51** | **23,785,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 510,516.51 | 23,785,900.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 23,785,900.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **36,240,521.08** | **6,332,675.46** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **36,182,000.00** | **6,399,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **36,182,000.00** | **6,399,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 36,182,000.00 | 6,399,000.00 |
| **225106** | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 25,679,000.00 | 6,399,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(36,182,000.00)** | **(6,399,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 58,521.08 | (66,324.54) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 36,025.22 | 94,546.30 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 94,546.30 | 28,221.76 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 179,512,371.00 | 307,746,254.36 | -25,184,107.88 | 462,074,517.48 |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **179,512,371.00** | **307,746,254.36** | **-25,184,107.88** | 462,074,517.48 |
| **C07** | Тайлант үеийн үр дүн | | | 14,968,612.90 | 14,968,612.90 |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **179,512,371.00** | **307,746,254.36** | **68,707,315.57** | 555,965,940.93 |
| **D01** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **179,512,371.00** | **307,746,254.36** | **68,707,315.57** | 555,965,940.93 |
| **D02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **179,512,371.00** | **307,746,254.36** | **68,707,315.57** | 555,965,940.93 |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | | | -194,059,465.42 | -194,059,465.42 |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **179,512,371.00** | **307,746,254.36** | **-125,352,149.85** | 361,906,475.51 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 553,281,413.48 | 553,281,413.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 548,382,413.48 | 548,382,413.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 524,596,513.48 | 524,596,513.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 341,385,553.00 | 341,385,553.00 |
| **210101** | Үндсэн цалин | 341,385,553.00 | 341,385,553.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,994,200.00 | 37,994,200.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 37,994,200.00 | 37,994,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,775,600.00 | 18,775,600.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 6,870,000.00 | 6,870,000.00 |
| **210302** | Түлш, халаалт | 11,205,600.00 | 11,205,600.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 700,000.00 | 700,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,606,750.00 | 20,606,750.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 2,333,000.00 | 2,333,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 3,900,000.00 | 3,900,000.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 880,000.00 | 880,000.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,709,750.00 | 2,709,750.00 |
| **210407** | Аж ахуйн материал худалдан авах зардал | 10,784,000.00 | 10,784,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 85,518,671.00 | 85,518,671.00 |
| **210501** | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 59,540,671.00 | 59,540,671.00 |
| **210502** | Хоол, хүнс | 25,978,000.00 | 25,978,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **210602** | Тавилга | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,815,739.48 | 18,815,739.48 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,928,303.48 | 17,928,303.48 |
| **210807** | Газрын төлбөр | 887,436.00 | 887,436.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,785,900.00 | 23,785,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,785,900.00 | 23,785,900.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,785,900.00 | 23,785,900.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,899,000.00** | **4,899,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,899,000.00 | 4,899,000.00 |
| **222001** | Тоног төхөөрөмж | 4,899,000.00 | 4,899,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 553,215,090.00 | 553,215,090.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 545,635,425.00 | 545,635,425.00 |
| **134002** | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 545,635,425.00 | 545,635,425.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 7,579,665.00 | 7,579,665.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1E+06** | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,579,665.00 | 7,579,665.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн “Өлгий сансар” эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дотор, сэргээн засах чиглэлээр хэвтүүлэн эмчлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэг чиг үүрэгтэй байгууллага юм.

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Аймгийн “Өлгий сансар” эмнэлэг нь ахмад өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй чанартай үзүүлж тэдний насжилтыг уртасгах, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтыг сайжруулах, эмнэлгийн дотоод халдвар гаргахгүй байх зорилго Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээ байгуулан гүйцэтгэлээр санхүүждэг байгууллага юм.

Аймгийн Засаг даргын харьяа аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг орон нутгийн өмчийн байгууллага.

“Өлгий сансар” эмнэлэг нь 2022 онд үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг чанартай аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэх, эндэгдэлгүй ажиллах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эмнэлгийн удирдлагын менежментийг сайжруулах, удирдлагын арга барилыг дээшлүүлэх
- Хүний нөөцийн тогтолцоог сайжруулах, ажиллагсдын ур чадварыг дээшлүүлэх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, шинэ техник тоног төхөөрөмжөөр хангах
- Байгууллагын соёлыг дээшлүүлж, үйлчлүүлэгчийн тав тух, аюулгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

“Өлгий сансар” эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. “Өлгий сансар” эмнэлэг 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Өлгий сансар” эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

“Өлгий сансар” эмнэлгийн даргын 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Өлгий сансар” эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.6 сая төгрөгөөр буюу 20.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 94.5 | 28.2 | -66.3 |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 95.598.7 | 89.320.1 | -6.278.6 |
| Үндсэн хөрөнгө | 442.295.6 | 402.003.1 | -40.292.5 |
| Нийт хөрөнгө | **592.988.9** | **491.351.4** | **-101.637.5** |
| Өр төлбөр | 37.022.9 | 129.444.9 | 92.421.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 555.966.0 | 361.906.5 | -194.059.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | **592.988.9** | **491.351.4** | **-101.637.5** |

Бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 129.4 сая төгрөг болж оны эхнээс 92.4 сая төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг 50.4 сая, бараа үйлчилгээний зардлын өглөг 0.9 сая, байгууллагад төлөх өглөг 41.1 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн данс 40.3 сая төгрөгөөр буурсан нь 6.4 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 46.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо тайлант оны үр дүнтэй холбоотой 194.0 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

"Өлгий сансар" эмнэлэг нь батлагдсан төсөвгүй байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

"Өлгий сансар" эмнэлэг нь 2022 оны үйл ажиллагааны төсвийн төслийг 685.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 545.6 сая төгрөгийн санхүүжилт авч, өмнөх оны санхүүжилтийн авлага 55.0 сая төгрөгийг барагдуулж, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 7.5 сая төгрөг оруулан нийтдээ 553.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн үйл ажиллагаа явуулжээ.

Гүйцэтгэлээр 546.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 6.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

#### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Аймгийн Өлгий сансар эмнэлэг 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Өлгий сансар" эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын "Анализ старт аудит" ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

"Өлгий сансар" эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг "Өлгий сансар" эмнэлгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 824.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0% байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аймгийн Өлгий сансар эмнэлэг завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 600.4 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 600.419.100.0 | 1 | 600.419.100.0 | 1009 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |